

# АРИУН СҮНСИЙГ СОНСОХ НЬ



**Варнэр Б., 11 настай, АНУ, Юта**

**Н**эг удаа, гэр бүлийн үдшийн үеэр ээж минь Ариун Сүнсний талаар ярьж байлаа. Ариун Сүнс ихэвчлэн бидэнд бодол төрүүлэх байдлаар ярьдаг гэж тэр хэлэв.

Тэр ингэж хэлэхэд би их гайхсан. Яг өмнө нь би Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, Ариун Сүнснийг сонсоход туслаач гэж гуйсан байлаа. Гэвч би Ариун Сүнс бодолд минь тэгж ярьж чадна гэж мэддэггүй байв. Амьдралын минь туршид намайг зөвийг хийхэд удирдан чиглүүлсэн бодлууд байсан. Одоо би тэдгээрийг Ариун Сүнснээс ирдэг байсныг мэдлээ.

Түүнээс хойш би Ариун Сүнснийг илүү ихээр анзаардаг болсон. Өнгөрсөн ням гарагт бид гэр бүлийн үдэш хийж байв. Энэ удаа гэрчлэлийн тухай байлаа. Гэрчлэл гэж юу байдгийг би мэддэггүй байсан. Тэгээд би ааваасаа асуусан. Тэр надад гэрчлэл гэдэг нь ямар нэг зүйлийг үнэн гэж мэдэхийг эсвэл итгэхийг хэлдэг гэж хэлсэн. Бид Ариун Сүнснээс өөрийн гэрчлэлийг хүлээж авдаг гэдгийг тэр хэлсэн. Тэгээд би хэрхэн Ариун Сүнснийг илүү анзаарч эхэлснээ бодтол, БҮҮМ! Надад мөн гэрчлэл байв!

Үүнийг мэдсэнээр би илүү аз жаргалтай болсон. Би Есүс Христийн илүү сайн дагагч болохыг мөн Ариун Сүнснийг үргэлж сонсохыг хүсэж байна. ●